



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 81

Мандалговь

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах,
үндсэн хөрөнгөд үнэлгээ тогтоож, худалдах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванхоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 6,285,600 /зургаан сая хоёр зуун наян таван мянга зургаан зуун/ төгрөгийн балансын үнэтэй 3,084,413.76 /гурван сая наян дөрвөн мянга дөрвөн зуун арван гурван төгрөг далан зургаан мөнгө/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Цагдаагийн кубоныг акталж, данснаас хасах, 500,000 /таван зуун мянга/ төгрөгийн балансын үнэтэй 312,500.03 /гурван зуун арван хоёр мянга таван зуун төгрөг гурван мөнгө/ төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий 19-69 ДУА улсын дугаартай КАМА маркийн автомашины худалдах доод үнийг 500,000 /таван зуун мянга/ төгрөгөөр тогтоон нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар (Б.Адъяасүрэн)-д даалгасугай.

3. Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ё.Сайхантуяа)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

3.1 Дуудлагын худалдаагаар худалдах тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгөх.

3.2 Сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, акталснаас гарсан материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэх.

3.3 Үл хөдлөх хөрөнгийг акталж, акталснаас гарсан хог хаягдлыг цэвэрлэж, чөлөөлсөн газрыг нөхөн сэргээж байгууллагын хэрэгцээнд зориулалтаар нь ашиглах.

3.4 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх.

3.5 Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны
өдрийн 81 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын актлах барилгын мэдээлэл

Д/Д	Хөрөнгийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглалтад орсон он	Ашиглалтын нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Актлах төрөл /1. Устгах 2. Худалдах 3. Сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах 4. бусад/
			Хэмжих нэгж	Биет хэмжээ						
1	Цагдаагийн кабон	Эрүүлжүүлэх	мкв	8	2007	36	6,285,600	3,201,186.24	3,084,413.24	1
							6,285,600 /зургаан сая хоёр зуун наян таван мянга зургаан зуун/ төгрөг			
Дүн										

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны
өдрийн 81 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэр лэсэн он	Ашиглалт ад орсон огноо	Тээврийн хэрэгслийн		Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Сери	Дугаар			Арлын дугаар	Моторын дугаар				
1	КАМА автомашин	КАМА SD4010 PD3	ДУА	16-69	2013	2013-11-13	LWU2P 22C3DK M01380	2540	15960	500,000	187,499.97	312,500.03
Нийт												
500,000 /таван зуун мянга/ төгрөг 187,499.97 /нэг зуун наян долоон мянга дөрвөн зуун есөн төгрөг эрэн долоон мянга/ төгрөг 312,500.03 /гурван зуун арван хоёр мянга таван зуун төгрөг гурван мянга/ төгрөг												